

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв



Institute for the Promotion of Business-Regional Collaboration
HOKKAIDO UNIVERSITY

“Эмэгтэйчүүдийн өнцгөөс харсан бизнесийн шинэ хэв маяг”

(Хоккайдо их сургуультай хамтарсан эмэгтэйчүүдийн
бизнес эрхлэлтийг дэмжих тусгай сургалт, воркшоп)

2026.09.16-17

2026 он

1) Танилцуулга:

Воркшопын зорилго:

Жижиг бизнест хашигдахгүйгээр, нийгмийн өнцгөөс харж үйл ажиллагаа, төсөл боловсруулж чадах эмэгтэйчүүдийг дэмжих.

- ✓ “Дуртай, сайн хийдэг зүйл” болон “өдөр тутмын мэдлэг” нь нийгэмд үнэ цэнтэй нөөц болохыг ойлгуулах.
- ✓ “Хэн нэгний бэрхшээл”-ээс эхэлж, түүнийг “арга зам” эсвэл “бизнес” болгон дахин боловсруулах сэтгэлгээний аргыг сурах.
- ✓ Бизнесээр дамжуулан хувь хүнээс эхлээд, бүс нутаг, цаашлаад нийгэм рүү харах өргөн хүрээний мэдрэмжийг хөгжүүлэх.
- ✓ Ирээдүйд бусад хүмүүстэй хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх эхлэлийг тавих боловсон хүчин бэлтгэх.

Хүлээгдэх үр дүн:

- Өөрийн “дуртай, сайн хийдэг зүйл, туршлага”-аа нийгэмд үнэ цэнтэй зүйл болгох.
- Өдөр тутмын анзаарсан зүйлсээ бизнес болгон хөгжүүлэх, системчлэх сэтгэлгээг эзэмших.
- Бусадтай хамтран ажиллаж, бизнесээ өргөжүүлэх хүсэл эрмэлзэл, төлөвлөх чадварыг хөгжүүлэх.

2) Хугацаа: 2026.09.16-17 (Лхагва, Пүрэв 14:00-17:00)

3) Хамрагдах хүн: Бизнестээ шинэ санаа олж авмаар байгаа болон бизнесийг салбарыг харах өнцгөө өөрчилмөөр байгаа бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон шинээр бизнесийн салбар руу орох хүсэлтэй эмэгтэйчүүд

4) Хамрагдах хүний тоо: 30 хүн

※Хүний тоо гүйцсэн тохиолдолд хугацаанаас өмнө бүртгэл дуусахыг анхаарна уу!

5) Сургалтын төлбөр: 380,000 төгрөг

6) Хичээл заах багш:

Шиина Нозоми (Ph.D)



Хоккайдогийн их сургуулийн Аж үйлдвэр, академи, орон нутгийн хамтын ажиллагааг дэмжих байгууллагын Онцгой эрх бүхий дэд профессор 2008 онд Хоккайдогийн их сургуулийн Анагаах ухааны сургуулийн Эрүүл мэндийн тэнхимийг төгссөн. Яаралтай тусламжийн эмнэлэгт ажиллахын зэрэгцээ бизнесийн удирдлагын магистрын зэрэг (MBA) хамгаалсан.

2014 онд Recrit Career компанийн борлуулалтын хэлтэст ажиллаж, Отарүгийн Худалдааны их сургуулийн цагийн багшаар ажиллаж байгаад,

2020 оноос Хоккайдогойн их сургуулийн Аж үйлдвэр, академийн хамтын ажиллагааг дэмжих байгууллагад ажиллах болсон. Тус байгууллагадаа Хоккайдогойн бүс нутгийн их сургуулиудад **энтрепренершип** (entrepreneurship) буюу **бизнес эрхлэх сэтгэлгээг төлөвшүүлэх** чиглэлээр ажиллаж байна.

Мөн 2016 онд Хоккайдод тусгайлан бүтээгдэхүүн хөгжүүлэлт, SNS маркетинг хийдэг K Project LLC зэрэг компаниудыг үүсгэн байгуулсан.

Дэлгэрэнгүй танилцуулга: <https://researchmap.jp/nozomishiina>

Канэширо Шүничио



Mirai Studio Inc. -ын CEO, үүсгэн байгуулагч

Окинавагийн Үндэсний Технологийн Коллежийн (Окинава Косэн) ахисан түвшний хөтөлбөрийг төгссөн. Суралцаж байх хугацаандаа оюутны гарааны бизнес эхлүүлж байсан туршлагатай.

Recruit Holdings компанид шинэ бизнес хөгжүүлэх, шинэ байгууллага, баг нэгж байгуулах, стартап компани худалдан авах (M&A) зэрэг төсөлд оролцож байсан.

Бие даан үйл ажиллагаа явуулж эхэлснээсээ хойш 8 стартап компани байгуулсан бөгөөд үүнээс: 4 компани хөрөнгө оруулалт татсан, 1 компани амжилттай зарагдсан.

Одоогоор Mirai Studio-г үйл ажиллагааныхаа төв болгон ажиллуулж, өөрөө хөрөнгө оруулалт удирдлагад нь оролцохын зэрэгцээ, Косэн (технологийн коллеж)-ийн инженерүүдийн хүний нөөцийн экосистемийг бүрдүүлэх, бүс нутгийн бизнесийн хамтын бүтээн байгуулалтыг хөгжүүлэх ажлыг идэвхтэй өрнүүлж байна.

Дэлгэрэнгүй танилцуулга: <https://miraistudio.co.jp>

7) Хөтөлбөр:

Өдөр	Агуулга	Цагийн хуваарь
9 сарын 16 /Лхагва/	STEP 1 Өнцгөө өөрчлөх нь “Бизнес гэж ер нь юу вэ?” - Нийгэмд шинэ үнэ цэнэ бий болгох үйл ажиллагаа гэдэг утгаар нь бизнес - Бизнесийг менежментийн үүднээс авч үзэх - Хүмүүсийг хөдөлгөх менежмент	Воркшопын цаг 14:00-17:00
	STEP 2 Бизнес рүү хөрвүүлэх нь “Жижиг бизнес гэж юу вэ?” “Үүгээр нийгэм үнэхээр өөрчлөгдөх үү?” “Дуртай”, “сайн хийдэг”, “туршлага” зэрэг хувийн нөөц бололцоогоо эргэн харах - Жижиг бизнесийн талаарх буруу ойлголтыг залруулж, боломжийг нь дахин тодорхойлох Асуудлыг хувьчилж биш, нийгэмчилж харах “Хэн нэгний бэрхшээл” → “Бүтцийн асуудал”	Завсарлага 15:30-15:45 /15 мин/

	Жишээ: Хоол хийхдээ сайн → Хоол тэжээлийн боловсрол / Ахмадуудын ганцаар хооллох асуудал • “Хэн нэгний бэрхшээл”-ээс санаа гаргах • Өдөр тутмын асуудлыг “бүтцийн асуудал” болгон харах өнцгийг сурах	
	STEP 3 Хувийн нөөц бололцоогоо дахин тодорхойлох “Гэрийн ажлын ур чадвар”, “бүс нутагтай холбоотой байдал”, “ээж хүний үүднээс харах өнцөг” нь үнэндээ хүчтэй бизнесийн нөөц. Эдгээр нөөцөд тулгуурлан бизнесийн санаа боловсруулах. • Хэнд /Юуг/ Яаж гэдгийг хялбар аргаар цэгцлэх • Үлгэр жишээ болох хүмүүсийн талаар мэдэх	
9 сарын 17 /Пүрэв/	STEP 4 Өргөжүүлэх боломжтойгоор сэтгэх Өөрөө хийж зарах → Бусдаар заруулах, захиалгаар хийлгэх, систем бий болгох гэсэн сэтгэлгээнд шилжих • Систем болон хамтрагчидтай хамт урагшлах санааг танилцуулах • 5 жилийн дараах ирээдүйг төсөөлөн, өөрийн бизнесээс гарах өөрчлөлтийн талаар бодох • Нийгэмтэй холбогдож, цар хүрээгээ тэлэх боломжийг олж харах	
	STEP 5 Ирээдүйд чиглэсэн асуулт тавих “Бизнес төлөвлөгөөгөө танилцуулах” “Энэ бизнес амжилттай болбол 5 жилийн дараа юу өөрчлөгдөх вэ?” • 1 сарын дотор хийх “жигжигхэн алхам”-аа сурталчлах • Илтгэл тавьж санал шүүмжлэл авах, хамтрагчидтайгаа холбоо тогтоох	

8) Бүртгэл: Доорх QR кодыг уншуулж бүртгүүлнэ үү.



9) Холбоо барих:



Утас:

7511-0879(Ext.3) , 8063-0879

И-Мэйл:

business.course@japan-center.edu.mn



Цахим хуудас:

www.japan-center.edu.mn



Фэйсбүүк хуудас:

<https://www.facebook.com/Mojc.business>